

ТӨВ БАНКНЫ САНХҮҮЖИЛТ

Мөнгөний бодлогын хэлтсийн эдийн засагч Э. Уранзаяа


Төв банк нь банкуудын нөөцийн нийлүүлэлтийг хянаснаар мөнгөний захын нөхцлүүд болон хүүд нөлөөлдөг бөгөөд энэхүү зорилгоо хэрэгжүүлэх үүднээс өөрийн үнэт цаасыг гаргаж байна. Өнөөгийн байдлаар Төв банкны үнэт цаас нь мөнгөний зах дээрх хамгийн идэвхтэй арилжааны хэрэгсэл болсоор байна.

2004 онд нийт 98 удаа ТБҮЦ-ны арилжаа явуулж 1021.2 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй үнэт цаасыг 1014.7 тэрбум төгрөгөөр борлуулсан байна. Үүнээс 52 удаагийн 7 хоногийн хугацаатай арилжаагаар 499.3 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй үнэт цаасыг 498.1 тэрбум төгрөгөөр, 26 удаагийн 14 хоногийн хугацаатай арилжаагаар 230.7 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй үнэт цаасыг 229.6 тэрбум төгрөгөөр, 14 удаагийн 28 хоногийн хугацаатай арилжаагаар 185.2 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй үнэт цаасыг 183.3 тэрбум төгрөгөөр, 4 удаагийн 91 хоногийн хугацаатай арилжаагаар 79.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй үнэт цаасыг 76.5 тэрбум төгрөгөөр, 2 удаагийн 1 болон 3 хоногийн хугацаатай нэмэлт арилжаагаар 27.2 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй үнэт цаасыг 27.1 тэрбум төгрөгөөр банкууд худалдан авчээ.


Монголбанк тайлант оны туршид өдөрт дунджаар 50.3 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй ТБҮЦ-ыг банкуудад байршуулж байсан нь өмнөх оныхоос 18.6 хувиар, сүүлийн гурван жилийн дунджаас 42.8 хувиар өссөн байна. Энэ нь эдийн засагт нийлүүлэгдэх мөнгөний хэмжээг сааруулах, мөнгөний үнэ цэнийг өсгөх буюу мөнгөний бодлогыг хатууруулсны илэрхийлэл юм. Оны эцэст Монголбанкнаас худалдсан үнэт цаасны хэмжээ 69.7 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй болжээ.

Монголбанк нь цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан мөнгөний агрегатуудын хэт өсөлтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бодлогын хүрээнд ТБҮЦ-ны зарлаж буй хүүг өсгөх, хэмжээг нэмэгдүүлэх болон бууруулах арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүллээ. Тухайлбал, Монголбанкнаас зарлаж буй 7, 14, 28, 91 хоногийн хугацаатай үнэт цаасны хүүг 1 дүгээр сард тус бүр 10 хувь

байсныг 4 дүгээр сард 12, 13, 14, 15 хувь, 7 дугаар сард 14, 14, 14, 15 хувь, 10 дугаар сард 15.5, 15.8, 15.9, 16.0 хувь болгон тус тус өсгөсөн.



ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү 2004 оны эцсийн байдлаар жилийн 15.75 хувьтай байсан бөгөөд тайлант оны туршид өдрийн жигнэсэн дундаж хүү нь 12.65 хувь байлаа.



Тайлант оны туршид Монголбанкнаас зарласан ТБҮЦ-ны гаргах хэмжээ дунджаар 73.1 тэрбум төгрөг байсан бол банкуудын ирүүлсэн саналын өдрийн

дундаж нь 51.8 тэрбум төгрөг, хамгийн өндөр нь 12 дугаар сард 69.7 тэрбум төгрөг, хамгийн бага нь 7 дугаар сард 35.3 тэрбум төгрөг байв.

2004 онд ТБҮЦ-ны хүүнд нийт 6.3 тэрбум төгрөг төлжээ.

	ТБҮЦ-ны хүүнд төлсөн зардал	Өссөн дүнгээр
1 сар	846,281,675.00	846,281,675.00
2 сар	192,134,475.00	1,038,416,150.00
3 сар	441,596,438.00	1,480,012,588.00
4 сар	762,229,833.00	2,242,242,421.00
5 сар	297,575,604.00	2,539,818,025.00
6 сар	468,142,123.00	3,007,960,148.00
7 сар	1,059,604,639.00	4,067,564,787.00
8 сар	326,164,444.00	4,393,729,231.00
9 сар	237,629,268.00	4,631,358,499.00
10 сар	370,979,315.10	5,002,337,814.10
11 сар	619,170,133.35	5,621,507,947.45
12 сар	698,039,746.52	6,319,547,693.97

Тайлант онд банкууд түр зуурын эх үүсвэрийн дутагдлаа нөхөх эсвэл өөрт байгаа илүүдэл нөөцийг үр ашигтай хэлбэрт байршуулах зорилгоор ТБҮЦ-ны хоёрдогч зах дээр нийт 379 удаа 476.7 тэрбум төгрөгийн арилжаа хийжээ. Үүнээс 81 удаагийн арилжаагаар 110.8 тэрбум төгрөгийн үнэт цаасыг банкууд хоорондоо арилжиж, 298 удаагийн арилжаагаар 365.9 тэрбум төгрөгийн үнэт цаасыг репо нөхцлөөр арилжлаа. Өмнөх онтой харьцуулбал банкуудын хоорондоо арилжсан үнэт цаас 40.7 хувиар буюу 32.0 тэрбум төгрөгөөр, репо нөхцлөөр арилжсан үнэт цаас 58.6 хувиар буюу 135.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөн банкууд банк хоорондын зах дээр 16.5 тэрбум төгрөгийн Төв банкны үнэт цаас болон 1.0 тэрбум төгрөгийн ЗГ-ын бондыг барьцаалан нийт 16 удаа 13.0 сая ам долларын болон 2.4 тэрбум төгрөгийн хадгаламжийн гэрээ хийсэн байна.


Монголбанк нь 2004 онд ТБҮЦ-ны арилжааг түргэн, шуурхай хийх, банк хоорондын захын орон зайг нэмэгдүүлэх зорилгоор ТБҮЦ-ны арилжааг электрон хэлбэрт шилжүүлэх талаар судалж ТБҮЦ-ны программ хангамжийг боловсруулан 2005 онд нэвтрүүлэхээр туршиж байна. Энэхүү программ хангамжийг ашигласнаар банкууд өөрсдийн онлайн холбогдсон компьютероос ТБҮЦ-ны арилжаанд шууд оролцох боломжтой болох юм.

Монголбанк нь эцсийн зээлдүүлэгчийн хувьд банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг богино хугацаанд хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор банкнаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн тодорхой төрлийн санхүүжилтийн

хэрэгслүүдийг ашиглан банкуудад зээл олгох үйл ажиллагааг явуулдаг. Тухайлбал 2004 онд Монголбанк нь ТБҮЦ-ыг хямдруулан худалдаж авах Хямдруулалтын санхүүжилт, тохиролцсон хугацааны эцэст банк өмнө нь худалдсан байсан ТБҮЦ-аа урьдчилж тохирсон үнээр буцаан худалдан авах Репо санхүүжилт, Овернайт зээл олгох зэрэг хэлбэрээр банкуудыг санхүүжүүлсэн байна.

Монголбанк нь 2004 онд банкуудад нийтдээ 150.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд тэдгээрийн хүүнд 183.0 сая төгрөг төлөгдсөн байна. 24 удаагийн хэлцлээр нийт 86.5 тэрбум төгрөгийн овернайт зээл олгосноос хүүнд нь 49.9 сая төгрөг, 20 удаагийн хэлцлээр 54.0 тэрбум төгрөгийн репо санхүүжилт олгосноор 56.3 сая төгрөг, 3 удаагийн хүсэлтээр 10.0 тэрбум төгрөгийн хямдруулалтын санхүүжилт олгосноор 76.9 сая төгрөгийн хүү тус тус төлөгджээ. Өмнөх онтой харьцуулбал хямдруулалтын санхүүжилт хэвэндээ, овернайт зээл 32.7 хувиар буюу 21.3 тэрбум төгрөгөөр, репо санхүүжилт 57.4 хувиар буюу 19.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төв банкны санхүүжилт



Дээрх графикаас харахад Худалдаа хөгжил, Анод, Хөдөө аж ахуй зэрэг банкууд нийт төв банкны санхүүжилтийн 77 гаруй хувийг /116.3 тэрбум төгрөг/ эзэлж байгаа бол Хадгаламж, Голомт, Монгол шуудан, Зоос, Улаанбаатар зэрэг банкууд 23 орчим хувийг /34.2 тэрбум төгрөг/ эзэлж байна.

Монголбанк нь 2004 оны 5 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн мөнгөний захыг хөгжүүлэх, банкуудад эх үүсвэр дутагдсан үед юуны өмнө банк хоорондын захаас эх үүсвэр хайх нөхцлийг бүрдүүлэх, банкуудын актив пассивын удирдлагыг сайжруулах зорилгоор овернайт зээлийн хүүний түвшинг шинэчлэн тогтоож, "ТБҮЦ-ны өндөр хүү+5" хувь болгож өөрчиллөө. Энэхүү өөрчлөлт орсноор банкуудын овернайт зээл авах нь эрс багассан. Тухайлбал, хүүний түвшинд

өөрчлөлт орохоос өмнө банкууд 70.1 тэрбум төгрөгийн овернайт зээл авч байсан бол өөрчлөлт орсны дараа 16.4 тэрбум төгрөгийн овернайт зээл авсан байна.